

ШИНЖААН ДАХЬ ТЭСРЭЛТ

*Олхонуд Д.Баярхүү**

БНХАУ-ын Шинжаан-Уйгурын Өөртөө засах Орон дахь лалжилт, салан тусгаарлах үзэл, түүний эсрэг Хятадын нам, засгаас явуулж буй бодлогын талаархи зарим судалгаа, түүний тусгал, нөлөөллийн тухай өгүүлэх болно.

Нэг. Хятадын эрх ашиг

Тухайн цагтаа СССР-ийн удирдагч явсан Л.И.Брежнев АНУ-ын Ерөнхийлөгч Р.Никсонд Хятадыг баахан муулж, “хятадууд итгэл эвддэг”, “жинхэнэ зорилгоо чадамгай нуудаг” хэмээн ярьсан нь бий санж¹. Америкийг Хятадтай цэргийн салбарт хамтран ажиллахаас сэрэмжлүүлэх нь тухайн үеийн Брежневийн чин санааны зорилго байв.

Би аль 1973 оны үйл явдлаас эшлэж байгаа боловч яг өнөөгийн цаг үед Хятадын тэр “жинхэнэ зорилгоо чадамгай нуудаг” чанарыг хөндөх гэж байна. Хөндсөн гарчигтаа оршил хайсаар 1973 он руу аялсан хэрэг л дээ. Ингэхэд «Лалын улс», «лалын терроризм»-ын талаар Хятадын байр суурь тун бүдэг бадаг явж ирснийг ажлаа. Энэ гамшигт үзэгдэл дээр Хятадын байр суурь юу вэ гэдгийг ч олж харахад хэцүү юм.

“Жинхэнэ зорилгоо чадамгай нуудаг” нь л харагдаад байна. Би судалж судалч эцэст нь Хятадын эрх ашиг нь явж явж оросуудын гар, зэвсгээр өөрийнхөө Шинжааны хөлсний дайчдыг устгуулах, тэднийг Сирид нь булшлуулах л юм байна гэсэн дүгнэлтэд хүрлээ². Сиридэх мөргөлдөөн, ерөөсөө «Арабын хавар»-аас үүссэн дүрвэгсдийн хямралыг Хятадаас тойруулж бултуулж, НҮБ-ын ивээлд хэрэгжих олон улсын хөтөлбөрт 100 сая ам.доллар хандивласнаар ам таглах юм

* Олон Улсын Харилцааны профессор

1 Леонид Млечин. Брежнев, *e-reading.club/book*

2 Пекин жаелагт смерти уйгурским боевикам в Сирии, но вмешиваться в войну не готов, *enta.ru/articles/2017/03/23/*

байна гэдгийг 2016 намар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 71 дүгээр чуулган дээр БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Кэцян зарлачихсан³. НҮБ-ыг байгуулалцсан, түүний Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүний нэг, дэлхийд хөгжил ба эдийн засгаараа хоёрт яваа гүрний байр суурь гэхэд чамлалттай хэмээн олон улсын ажиглагчид тэмдэглэж буй.

Тэр ч бүү хэл “Дүрвэгсдийг тийм их тоогоор шилжүүлэн байршуулах нь тогтвортой байдалд цохилт болж, эдийн засгийн хөгжлийг бусниагаад зогсохгүй, олон улсын терроризмд бэлээхэн хөрс бий болгоно”⁴ хэмээн Хятадын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд хэлсэн нь нэг талаас маш зөв, нөгөө талаас дэлхийн гүрэн болж яваа их өрхийн дэд тэргүүний үг гэхэд арай чамлалттай юм шиг. Маш зөв гэсэн нь манай Монгол мэт бага, буурай улсад хамаарах үг. Учир нь жил бүр 3000 дүрвэгчийг Сири, Иракаас ав, эсвэл авахгүй гэвэл жил бүр 5 сая ам.доллар төл гэсэн шаардлагыг⁵ АНУ-ын ТНБД-ын амнаас сонссон хүний хувьд би “маш зөв” гээд байгаа хэрэг.

Хоёр. Бээжингээс алдуурсан уйгурын террористууд

Манай Ховд, Баян-Өлгий аймагтай хил залгаад цаана нь Шинжаан-Уйгурын Өөртөө засах Орон (ШУӨЗО) гэж нэг том субъект БНХАУ-ын бүрэлдэхүүнд бий. Зарим нэг мэдээ сэлтээр бол уйгураас хэдэн мянгаараа Сири рүү дүрвэж гараад «Лалын улс» ба үүнтэй төстэй лалын экстремист, жихадист бүлгүүдэд хуваагдаад тулалдаж байгаа аж. Тэд дайнаа дуусгаад Хятадаа эргэж ирнэ гэдэг Бээжингийн эрх баригчдын хувьд хамгийн том аюул болох ба тэгүүлэх бүх гарц боломжийг нь хэр чинээндээ хаагаад байгаа. Гэм нь яаж ийгээд Хятадад нэвтрэн орж, Шинжаандаа ганц нэгээрээ очиж л таарна. Бүх гарц боломжийг хаана гэдэг нь Сирид байлдаж буй, исламистуудад элсэгдсэн уйгур, хасаг, чантуу, өөр мусульман хэн ч бай Хятадын иргэн л юм бол аль болох Сирийн цэргийн ба Оросын агаар-сансрын цэргийн довтолгоонд түлхүүхэн өртөөд, тэндээ үхээд байх ёстой юм байна. Харин Хятад өөрөө Сири дэх мөргөлдөөнд хэзээ ч оролцохгүй, тэгэхэд бэлэн биш гэдгээ ямагт зарлана. Брежневийн оношлосноор

³ China pledges additional \$100 mln in refugee aid, english.cntv.cn/2016/09/20/

⁴ Мөн тэнд

⁵ Д.Баярхүү: Цэргийн эвсэл, дүрвэгсдийн асуудалд манай улсын төвийг сахих байр суурь зөв нь харагдсан, eagle.mn 2017.02.16; baabar.mn – bayarkhuu.nittlelch.mn, 2017.02

“жинхэнэ зорилгоо чадамгай нууна”.

Сирид шинжааны иргэд олноороо байна гэдгийг зарлахгүй явж явж 2017 оны гуравдугаар сард анх удаа Хятадад албан ёсоор зарлаж хүлээн зөвшөөрчээ. Гэтэл олон жилийн өмнөх ноцтой баримтыг оросууд гаргаж иржээ. Тэр баримтыг дэлхийн хэвлэл мэдээллээр шуугиулж бөөн сенсаац дэгдээх нь тэр⁶. Шинжааны исламистуудын олонхи нь «Жабхат Фатх ал-Шам» (хуучин нэр нь «Жабхат ан-Нусра») гэх бүлэгт элсэн 2012 оноос тулалдаж байжээ. Туркестаны лалын нам гэгчтэй «Аль-Каеда» холбоо тогтоогоод өөрийн Сири дэх салбар болох «ан-Нусра» руу уйгурчуудыг нийлүүлж байгаа баримтыг оросууд аль эрт олж мэджээ. Сүүлдээ шинжааны иргэд олшроод зарим нь Ирак дахь «Лалын улс»-ын нийслэл Мосулд очиж хар тугийн дор дайнд оржээ. Сири, Иракт өрнөсөн дайны явцад туркестан дайчид эр зориг, байлдах ур чадвараа жинхэнэ харуулсан, Туркестаны лалын намын хяналтад буй алга дарам нутаг дэвсгэр ч бий хэмээн оросын «лента.ру» сайт барим тавим бичжээ⁷. Шинжааны уйгур дайчдын мэдэлд Сирид сургуулилалтын бааз, бүр нам-улс төрийн сүрхий бүтэц байгаа гэнэ. Ийнхүү социалист БНХАУ-ын иргэдийн мэдлийн террорист бааз Сирид буй болж бэхжсэн үлгэр цаашаа өрнөнө.

Гурав. Гол аюулын эхлэл

Гадаадын зарим нэг судлаачдын (америкийн Жейкоб Зенн, Ж.Адамс гэх мэт) үзэж байгаагаар, Туркестаны лалын нам гэх исламист нууц байгууллагынхан Хятадын Шинжаанд “Дорнод Туркестан” гэсэн нэрээр салан тусгаарлаж, улмаар бие даасан улсаа байгуулж зарлахыг зорилгоо болгож байгаа ба хэтдээ энэ намын стратеги нь “Төв Азийн Лалын Халифат”-ыг байгуулж, түүндээ Казахстан, Киргизстан, Узбекистан, Туркменистан, Тажикистаныг хамруулах явдал ажээ. Ийнхүү Төв Азид лалын хүчтэй анклав үүсгэх цөм нь одоогоор Шинжаанд төвлөрч байна хэмээн тэр судлаачид үзсэн байх юм⁸. Хятадын Шинжаанд нууцаар ажилладаг байж болох энэхүү Туркестаны лалын нам гэгчийн удирдагч Абдул Шакур Туркистани гэдэг нөхрийн

6 Syria says up to 5,000 Chinese Uighurs fighting in militant groups, reuters.com/ May 11, 2017

7 Пекин желает смерти уйгурским боевикам в Сирии, но вмешиваться в войну не готов, lenta.ru/articles/2017/03/23/

8 J Z Adams. Turkistan terrorists hurt Uyghur cause, Asia Times, Feb 22, 2012

мэдэгдэлд Туркестаны лалын намын ойрын зорилго, үйл ажиллагааг дараахи байдлаар тунхаглажээ. Үүнд:

Хятадын мусульманчуудын боловсрол нь шашнаасаа илт хоцорч байгааг бүх нийтийн боловсролын салбарт нөхөх,

Хятад хэлийг албадаж заадгийг болиулах,

Хятадын төвийн мужууд руу (өөрсдийнх нь нэрлэдгээр “Дотоод Хятад” буюу Бээжин, Шанхай, Гуанжоу) ажлын байр хайх нэрээр мусульман бүсгүйчүүд Шинжаанаас шилжин явдгийг таслан зогсоох,

Хүн амын төлөвлөлтийн “нэг өрхөд нэг хүүхэд” бодлого Шинжаанд явуулж байгааг таслан зогсоох, энэ нь уйгур хүн амд ноцтой аюул хэмээн үзэх,

Мусульман хүн амын дотор хятад-хан иргэдийг олноор нь суурьшуулж байгааг таслан зогсоох,

Туркестаны байгалийн үнэт нөөц баялаг, ялангуяа газрын тос олборлон цөлмөж байгааг таслан зогсоох (Хятадын газрын тосны хэрэгцээний 30 хувийг хангадаг),

1964-1996 онд Шинжааны Лоб-Нуурын районд 46 удаа цөмийн зэвсэг туршсаныг эсэргүүцэж нөхөн төлбөр авах явдал гэсэн байв⁹.

Хэдийгээр ийм мэдэгдэл интернэтээр хэдэн жилийн өмнө цацагдсан ч энэ намын талаар, Шинжаанд үе үе гардаг үндэстэн хоорондын мөргөлдөөнд энэ нам холбоотой эсэх, зарим нэг террорист халдлагыг энэ нам үйлдсэн эсэх дээр тодорхой нотлогоо алга. Хэн хаанаас тараадаг нь үл мэдэгдэх намынх нь сайт дээр Шинжаанд гарсан террорист халдлагын хариуцлагыг өөртөө хүлээлээ гэж бичигддэг ч яг удирдаад зохион байгуулчихсан гэдэг нь Хятадын тусгай албадаар нотлогдоогүй.

Террорист халдлагууд гол төлөв Кашгар хотод гардаг. Кашгар нь Шинжааны баруун өмнөдод улсын хилд ойрхон орших ба энд уйгурчууд нь хятад иргэдээсээ олон. Кашгарт 2011.07.30-нд хятад иргэд олноороо цугларсан гудамжинд анхны дэлбэрэлт болсон, дараа нь хоёр уйгур залуу ачааны тэрэг булаан авч хүмүүс рүү дайрч тааралдсан болгоноо хутгалж алж хядсан, маргааш нь буюу 31-нд хоёр ч газар

9 Мөн тэнд

бөмбөг тэсэлж, 10 орчим уйгур залуус хавьтсан болгон руугаа хутга барин дайрч, хутгалж, хоолойг нь хэрчиж аллага үйлдсэн баримт бий. Энэ бүхний хариуцлагыг Пакистанд байрладаг “Дорнод Туркестаны лалын хөдөлгөөн” хүлээсэн ба эл хөдөлгөөнөөс Туркестаны лалын нам үүссэн гэж үздэг.

“Дорнод Туркестаны лалын хөдөлгөөн”-өөс 2008 оны Бээжингийн олимпын наадмыг тасалдуулахаар хэд хэдэн дэлбэрэлт хийнэ хэмээн олимпын өмнө эл хөдөлгөөний нэг удирдагч Сейфулла зарлаж, Шанхай, Куньмин, Вэньжоу хотод бөмбөг тэсэлж, хэд хэдэн хүний аминд хүрсэн¹⁰. Гэвч хожим нь эдгээр дэлбэрэлт нь лалынхны үйлдсэн хэрэг биш болж таарсан. Лалынхан үйлдсэн байлаа ч түүнийг ахуйн осол, болчимгүй хятад иргэний танхайрал байсан мэтээр ойлгуулах нь хятадын тусгай албаны тухай үеийн бодлого байсан байж болох юм.

Дөрөв. Суртал нэвтрүүлэг

Туркестаны лалын нам нь интернэт сайтуудад суртал ухуулгын шинжтэй материалууд тавьж өөрийгөө нэгэнт таниулжээ. Тус намын хэвлэлийн алба – “Лалын дуу хоолой” (“Islam Avaz”) гэгчээс Узбекистаны исламист хөдөлгөөнтэй зэрэгцэх томхон хүчин Шинжаанаас төрж байгаа мэт сэтгэгдлийг лалын ертөнцөд түгээх, тэгснээрээ анхаарлын төвд орж ирэх, гадаадаас санхүүжилт олох зорилгоор хийгдэж буй алхам гэж үзэж болох юм¹¹. Орос хэлээр Төв Ази руу хандуулсан мэдээлэл тэндээс түгээж байсан. “Жамаат Туркестан” гэх мужахедуудын бүлгийг төлөөлж Яхья гэгч нөхөр оросоор мэдэгдэл хүртэл хийж байсан¹². “Жамаат Туркестан” гэдэг нь пакистаны Зона гэх омгийн оршин суудаг бөглүүд нутаг – Хорасан мужид байрладаг, иймд “Хорасанаас Жамаат Туркестан холбогдлоо” гэж мэдээллийн сайтын магнайд бичжээ. “Жамаат Туркестан” гэдэг нь Туркестаны лалын намаа нэрлэж байгаа хэрэг болов уу. Афганистаны хойд эзэнгүй зэлүүд нутгаар дамжаад Төв Азийн салафит,жихадист лалууд Хорасан руу дүрвэн очдог, бүгдэг гэх мэдээлэл Афганистан дахь НАТО-гийн хүчнийхэнд бий.

10 The East Turkestan Islamic Movement (ETIM),

The Council on Foreign Relations (CFR), cfr.org, Last updated September 04, 2014

11 J.Z.Adams. Turkistan terrorists hurt Uyghur cause, Asia Times, Feb 22, 2012

12 Доклад Института стратегических исследований США о структуре подполья на Северном Кавказе. Глава 2, golosislama.com, 23 Мая 2013

Афганистан руу НАТО 2001 онд халдсан явдал нь 1949 онд Туркестан руу Хятад халдсан, Орос Тагарстан руу халдсантай адил, “Иймд энэ бүх газар нутаг нь Аллахад харьяалагдана, лалын эсрэг хэн байна, түүнтэй бид тулалдалахад бэлэн!” гэсэн андгай тангарагийн үгс Яхья гэгч нөхрийн оросоор хийсэн мэдэгдэлд байна. “Хорасанд жихадист исламистууд бид шариатын хуулиар аж төрдөг, зэр зэвсэгт суралцдаг, партизаны дайн болон гудамжны байлдааны дасгал сургууль хийдэг” хэмээн Яхья ярьжээ¹³.

Туркестаны лалын намын хэвлэлийн алба – “Лалын дуу хоолой” (“Islam Avaz”) гэдгээс хэд хэдэн цуврал мэдээлэл 2011 оноос сайтдаа тавьжээ. “Мөргөлчдийн аялал жуулчлал” (“Tourism of the Believers”) гэх видео сэтгүүл¹⁴ хүртэл явж байна. Үүнээс өмнө “Жамаат Туркестан”-аас эрхлэн 2008-2011 онд 9 онлайн–сэтгүүл гаргаж, түүндээ Шинжаан дахь лалын шашны түүх, Хятадын эсрэг жихад дэгдээж шашин – соёлоо аврах тухай, дэлхийн улс орнууд дахь исламист хөдөлгөөний тухай мэдээлэл цацаж байсан аж. Дараа нь байнгын онлайн-видео сэтгүүлтэй болж, суртал нэвтрүүлгээ тогтмолжуулсан нь тэр ажээ.

Тав. «Арабын хавар» Хятадад тун халтай тусчээ

«Арабын хавар» дэгдсэн оргил үед нь би Каирт алба хашиж таарсан, тэр тухай эрхбиш гадарлана. Ганц юм анхаарлын төвд байсаар байна. Тэр нь АБНЕУ-д суугаа Хятадын Элчин сайд Сун Айго гэх найзын маань хэлж байсан үгс:–Египетэд аюулгүй байдал чухал, тогтвортой байдал чухал. Явж явж ардчилсан хувьсгал чухал биш болж таарсан. «Арабын хавар»-ыг баяр баясгалангүй угтаж байгааг хятадын дипломатчид алхам тутамдаа илэрхийлж байсансан¹⁵.

Тэднийг зөвтгөх юм зөндөө байсан ба байна чиг. Ардчилсан хувьсгалын зарчимд хятадууд дургүүдээ биш юм. Ийм хувьсгалт доргилтын дараа лалын ергөнц яах бол, тэр нь Шинжаанд буруугаар халдварлах вий гэсэн айдас, сэрэмжлүүлэг байсныг нь би зөв гэж үздэг. Ардчилаад л, вестернизац явагдаад л сайхан болчихно хэмээн өрнийнхөн хүсч байсан нь одоо юу болчихоод байна вэ? Улс төрийн

13 Мөн тэнд

14 archive.org/details/IslamAwazi-Tourism-Of-The-Believers

15 Монгол Улсаас АБНЕУ-д суугаа ЭСЯ-ны шуурхай мэдээ, 2011 № 3

ислам, радикализм хоёр холилдоод, исламистууд гялалзаад өгнө гэдгийг хаа очиж Орос, Хятад хоёр л зөв олж харсан байдаг юм.

Хятадын “Ойрхи Дорнодын бодлого” яах аргагүй Сири дээр төвлөрч байгаа нь Башар Асадын дэглэм, шиит-алавитууд, христианчуудын цөхрөл, хэлмэгдэлтэй холбоогүй, гол нь тэнд Шинжаанаас үй олон уйгур, хасаг, мусульманчууд зугтан очиж, тэр улсын иргэний дайнд хутгалдан орсноос үүдэлтэй. Хичнээн шинжаан иргэн тулалдаж байгааг Дамаск дахь Хятадын Элчин сайд, ЭСЯ мэдэж байж таарна. Тэр тухай тэдний амнаас үг унана гэж байхгүй. Харин Бээжинд суугаа Сирийн Элчин сайд Имад Мустафа хэвлэлд зарлаад тавьчих нь тэр. “Танай 5000 дайчин манай эх оронд бидний эсрэг дайтаж байна” гэжээ¹⁶. Байлдаан болж буй бүс нутгуудад Туркестаны лалын намын гишүүд-уйгурын сепаратистууд нийт 2000-2500 хүн байна хэмээн хоёр жилийн өмнө Арабын хэвлэлүүд шуугисан. Тэрхүү “5000” гэдэг тоонд их учир бий хэмээн зарим хэвлэлд бичсэн. Зэвсэг агссан уйгур боевикууд биш, тэднийг дагаж очсон гэр бүлийнхэн, эхнэр хүүхдүүд, бүр өвгөд хөгшид нь ороод тийм тоо гарсан хэмээн бичсэн нь анхаарал татна.

Зургаа. Шар Чечень - Уйгур

БНХАУ-ын төр-засаг Шинжааны уйгурын сепаратизмын асуудлыг шийдвэрлэхийн тулд ШҮӨЗО-ыг хөгжүүлээд, эдийн засгийг нь цэцэглүүлээд байвал болно гэж үздэг. Тэр зорилгоор Шинжаан руу асар их хөрөнгө оруулсан ба Өрөмч хот гэхэд л Хятадын ямар ч хотоос дутахгүй орчин үеийн супер, мега хот болж хувирсан. Гэтэл ийм амжилтын цаана өөр бэрхшээл, хямрал нүүрлэж үлджээ. Нийгмийн тэгш бус байдал хэвээрээ байгаа, ажилгүйдэл өссөн, хээл хахууль дийлдэхээ больсон, шинжааны мусульман иргэдийн нийгмийн статус нь дорой, хятадын нийгэмтэй интеграцчилагдаагүй гэх мэт. Энд Хятадын төрийн бодлогоос гадна мусульманчуудын өөрсдийнх нь дутагдал оршиж байгааг хэлж сануулсан үг өгүүлбэр нэн бага. Хятад өөрийнхөө бүтээснийг магтаад байхаас шинжааны тэр уугуул хүн амын тархи толгой руу орж судалгаа хийсэнгүй.

БНХАУ-ын энэ мужид коммунист үзэл суртлаасаа илүүтэй лалын

16 Syria says up to 5,000 Chinese Uighurs fighting in militant groups, reuters.com/ May 11, 2017

шашны мухар сүсэг хэтрээд, лалжилт явагдаад, лаллаг байдал нь доозоо хэтрүүлснийг Хятадын эрх баригчид хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Лалын шашныг бусад шашнаас дээгүүр тавьдаг, бусад шашинтан ба шашингүйчүүдийг лалын шашинд оруулахын хүсэл болдог, Аллахын байлдагчдыг механикаар олшруулах сүсэгтээ хэт автаад төрөлтөд хяналт тавих боломжгүй болгосон, Мекка руу мөргөл үйлдэж “хаж” болохоор явагсаддаа Бээжин хяналтаа алдсан, Булангийн орнууд шууд биш ч, шууд бусаар исламизмыг санхүүжүүлдэг гэх мэт олон шалтгаан энд бий юм. “Соёлын их хувсгал”-ын өс хонзон ч амь бөхтэй үлдсэн байж магад.

Ингэхэд Оросын Чечень дарьгай торх болон хувирч байгааг оросын өөрийнх нь эрдэмтэн судлаач, сэтгүүлч, зарим улс төрчид төрдөө анхааруулсаар байгаа ба тэд Шинжааныг “Шар Чечень”¹⁷ хэмээн нэрлэх болсон нь санаандгүй үгийн таавар бус, бодитой болоод л тэгсэн хэрэг болов уу. Чухамдаа Рамзан Кадыров л чеченийн хийрхлийг дараад байгаагаас бус Москвад Путин эзгүйрвэл Чечень яг тэсрэнэ хэмээн үзэх гутранги прогноз түгээмэл байна.

Ингэхэд яагаад “Шар Чечень” гэх болов? Үндсэндээ ШУӨЗО-ы уйгурчуудын ихэнхи нь Хятадын хөгжил дэвшил, Хятадын соёл, Бээжингийн өгөөмөр сэтгэлд гутруу ханддаг. Тэр нь ямар нэгэн зөрчлийн далд хэлбэр байж болно. Мусульманчууддаа Хятадын төр сая саяар нь мөнгө өгөөд байдаг, харин нөгөөдүүл нь тэр мөнгийг нь хуримтлуулаад халифат байгуулах хүсэлтэй хэмээн «лента.ру» сайтын сэтгүүлч Шинжаанд очоод бичжээ. Тэнд радикал-исламистууд ба коммунист-атеистууд аль алин нь зэрэгцээд байж байгаа гэж тэр орос сэтгүүлч бичжээ.

Долоо. Туркестан

Барагцаагаар 200 жилийн өмнө Туркестан гэх нэгдмэл этно-соёлын бүс нутаг дорно хэсгээ Манжийн Чин улсад, баруун хэсгээ Хаант Орост хуваалгасан. Хилийн шугамын хоёр талд казахууд, киргизүүд, чантуу нар, тажикууд, уйгурууд аль алин нь бий. Угсаатны зүйчдийн үздэгээр Шинжааны уугуул олонхи болох уйгурууд нь хэл ба зан заншлаараа узбекуудтай (чантуу) төстэй буюу төрөл мэт. Эрт

17 Желтая Чечня, lenta.ru, 15 ноября 2017

дээр үед Дорнод Туркестан нь Төв Ази, Хятадын аль алин руу нь нөлөөлөхүйц хүчирхэг улс байсан гэдэг. 1759 онд манж-хятадын цэрэг энэ улсыг эзэлж аваад шинэ нэр хайрласан нь Шинжаан¹⁸ («Шинэ хил») гэж хэвшээд өнөө хүрчээ. Тэр цагаас хойшхи Уйгурын түүх гэж бас баахан драм буй. Лав 4 удаа Хятадын эсрэг босч тэмцжээ. “Цусыг цусаар” гэсэн зарчмаар тэмцэж ирсэн¹⁹.

Шинжаанд Оросын нөлөө байсны илрэл ч эдүгээ хадгалагдан үлдсэн. Халбага (ложка), сэрээ (вилка), сонин (газета), машин (машина), жолоо (руль) гэх орос үгс Шинжаанд яг тэр утгаараа хэрэглэгдэж байна. Оросууд анх 1871 онд цэргээрээ Кульжа хотыг (хятадууд Инин хот гэж нэрлэнэ) эзэлж авснаар ул мөрөө үлдээжээ. Арван жилийн дараа Манжийн эзэнт гүрэн энэ хотыг эргүүлж авчээ. Оросуудыг дагаад 45 мянган уйгур хүн Казахстан, Киргиз рүү дүрвэн суурьшжээ. Ганц уйгур гэлтгүй хасагууд ч үлэмж тоогоор дүрвэсэн, зарим нь Ар Монгол руу нүүдэллэсэн хэмээн түүхийн эх сурвалжуудад буй.

1944 онд Улаан армийн ил далд дэмжлэгтэйгээр уйгурууд Шинжааны баруун хэсгийг хяналтдаа авч, «Дорнод Туркестаны БНУ» гэгчээ тунхаглажээ²⁰. Нийслэл нь мөнөөх Кульжа хот болж таарна. Уйгурын армид зөвлөгч сургагчаар зөвлөлтийн олон офицер тэнд ажиллаж байжээ. 1949 онд Мао Зэдун тэргүүтэй ХКН Хятадад засгийн эрх авмагц Кремль үзэл суртлын холбоотноо цааш түлхчихгүйн тулд «Дорнод Туркестаны БНУ»-аас ашиг сонирхлоо татаж авсан ба хоёр талыг эвлэрүүлэхээр зуучлагчийн үүрэг гүйцэтгэхээр амлажээ. «Дорнод Туркестаны БНУ»-ын бүх Засгийн газрын гишүүдийг Алма-Атад урьж, тэндээсээ Бээжин рүү ниссэн боловч онгоц сөнөж, дагалдан уйгурын залуу БНУ-ын бүх удирдагч хорвоогоос оджээ. Онгоцыг зөвлөлтийн чекистүүд хэргээр дэлбэлсэн хэмээн уйгурчууд өнөө ч үзсэн хэвээр, оросууд биднээр ямагт доог тохуу, хөзөр хийж ирсэн хэмээн ярих ахмад хижээд уйгур хүн Шинжаанд одоо ч олноороо бий гэлцэнэ.

18 Хятад үгийг кирилл рүү галиглавал “Синьцзян” хэмээн бичдэг, тэгж ч хэвшүүлсэн.

19 Эдүгээ Сири, Иракт «Лалын улс» бүлэгт уйгурууд олноороо элсэж дайтсан нь Хятадын эсрэг бослогынх нь нэг үе шат гэнэ.

20 Оспан хэмээх хасагийн дайчин баатар энэ үед алдаршиж, Шинжаан-Монголын хил дамнан байлдаж явсан түүх энэ үед мөн хамаарна.

Тухайн үедээ Туркестанд дан оросууд эзэгнээд байсан бус XIX зуунд Хаант Оросын харгислалаас дүрвэсэн оросууд²¹ хэдэн мянгаараа хил даван Хятадын Алтай руу дүрвэж очсон, суурьшсан. Кульжа хотод тэдний үр сад, “цэвэр цусны” славян, оросуудын жижиг квартал, орос сургууль, шарилын газар одоо болтол бий аж. Хятадын Засгийн газрын шийдвэрээр тэнд Пасха, Зул сарын баяр тэмдэглэдэг, оросын үнэн алдартны сүм босгосон, тэгэхдээ тэд нь ОХУ-тай холбоотой байх албагүй, Оросын РЦНК гэх төвтэй холбоо тогтоох гэснийг нь хятадууд цээрлүүлсэн баримт буй²².

Найм. Шинжаан дахь одоохи зөрчил

Хоёр өөр соёл, хоёр өөр иргэншлийн зөрчлийг бодитой олж харья гэвэл Шинжааныг зорь гэх санаагаар бичигдсэн нийтлэл мэр сэр тохиож байна. Энд шашин гэж тодотгохгүй байгаа нь бүр ч эргэлзээтэй²³. Нэг ёсны апартеид бодлого явагдаж байна гэсэн нь ч буй. Хятад ресторан, гуанзуудад хооллодог уйгур хасаг хүн гэж ерөөсөө байхгүй. Хятад дэлгүүр, заххаас хоол хүнс цуглуулахгүй, цаг асуухад хятадууд нь санаатайгаар Бээжингийн цагаар хэлнэ, уйгур хасагууд нь Алма-Атагийн цаг хэлнэ.

Төрөлтийг хязгаарлах тухай Хятадын хууль тогтоомж шинжааны мусульманчуудын итгэл үнэмшил, шашныг доромжилж байна. Мусульманчууд буруу номтны захиргаанд амьдрах ёсгүй. Хэрэв үүнийг хүлээн зөвшөөрөхгүй бол ямар юмных нь мусульман гэхэв, тэр бол өөрөө буруу номтон, мунафик (хоёр нүүрт) мөн хэмээн өвгөжөөр уйгур хүн орос сэтгүүлчид айж ичилгүй ярьжээ²⁴.

Уйгур хасагуудын шашинжсан төрх нь тэднийг орчин цагийн нийгэмтэй нь интеграцад оруулахад саад болж байгааг Хятадын эрх баригчид маш сайн ойлгодог. Тиймдээ ч 18 нас хүрээгүй хүүхэд, төрийн албан хаагчид мечетэд очиж мөргөл үйлдэхийг хориглох хуультай. Тийм зарлал Шинжааны бүх мечетийн ханан дээр өлгөөстэй. Бээжин дэх Шашны эрх эрхлэх хорооноос шашны хөгжилд нь хяналт тавина, исламын лам нарыг нэр дэвшүүлэхдээ тэр хорооны Шинжаан дахь

21 Тэднийг оросын старообрядцы гэнэ. Тэд нь хасаг, тувачуудад модон байшин, банн нэвтрүүлж соёлжуулсан гэлцдэг.

22 Желтая Чечня, lenta.ru, 15 ноября 2017 – мэдээллээс эшлэв.

23 Политические проблемы в Китае, Iragir.am, 05 Февраля 2010

24 Желтая Чечня, lenta.ru, 15 ноября 2017 – мэдээллээс эшлэв.

Шинжаан дахь тэсрэлт

салбар хорооноос хянана. Шинжааны тэр хороонд Баасан гаригийн өглөө бүх имам цугларч, Баасан гаригийн мөргөлийн дэг жаяг, явцыг тохиролцоно. Мусульманчуудын зан үйлтэй холбоотой алив нэгэн арга хэмжээгээ эрх баригчдад заавал дуулгаж, зөвшөөрөл авдаг хэмээн Кашгарын нэг имам ярьсан байх юм²⁵.

Араб ертөнцөд дайн мөргөлдөөн ширүүсч, лалынхан өвөр хоорондоо зөрчилдөөд ирмэгц Хятадын Засгийн газар Шинжаан дахь шашны хязгаарлалтаа улам чангалжээ. 2017 он хүртэл гэрлээгүй уйгур, хасаг охид гивлүүр зүүж болдог байсныг ШУӨЗО-ы эрх баригчид 2017.04.01-нээс тусгай зарлиг гарган хоригложээ. Гивлүүр нь эрчүүдийн дур хүслийг төрүүлэхийн (гэмт хэрэгт хүргэх урхагтай гэжээ) сацуу эмэгтэйчүүдийн эрх чөлөөг хязгаарладаг учраас тэр гэнэ. Терроризмын эсрэг Хятадын хуулийн дагууд тэгж чангаруулахаас өөр арга байгаагүй аж. Тэгж чангаруулсан зарлиг гаргахдаа Жихад, Имам, Ислам, Коран, Мекка, Саддам, Хаж гэсэн үгс, лалын хагас хавирган сарны бэлгэдлээс үүдэлтэй бүх нэрсийг хориглож, «террорыг хөхиүлсэн, харгислалыг дэвэргэсэн» зохиол бүтээл туурвисан лалын эрдэмтдийг ч нэрлэж болохгүй гэжээ. Эрчүүд сахлаа хэт урт ургуулах нь уйгурын салан тусгаарлагчдын илт илэрхийлэл гэж үзсэн учраас бас хориглох нь зөв болж таарчээ²⁶.

Шинжааны хил залгаа Ганьсу мужийн Гуанхэ хэмээх уездыг шинэхэн жишээ болгож болно. Тэндхийн хүн амын 98 хувь нь хотон, дунсян үндэстэн, бараг бүгдээрээ исламд сүсэглэнэ. 2016 онд мужийн Боловсролын департамент нь дунд сургуулиуд, цэцэрлэг яслиудад шашны зан үйл, ажиллагааг хориглосон. Хүүхдийн цэцэрлэгт бяцхан жаал чанга дуугаар Коран судраас уншиж буй бичлэг тарсны дараа эрх баригчдаас ийм шийдвэр гаргажээ. Сургуулийн амралтаар сурагч багачууд мечетэд зочлохгүй байх шийдвэрийг 2018 он гаргаад гаргачихлаа. Шашны ямар нэгэн объектэд ч очиж болохгүй. Сургууль, шашин хоёрыг төрөөс тусгаарлана, боловсролын тогтолцоотой зөрчилдсөн аливаа арга хэмжээнд шашныг ямар нэг байгууллага, хувь хүн ашиглах нь хориотой хэмээн тэр шийдвэрт заажээ²⁷.

25 Пятничные проповеди, islam.ua/library/pyatnichnye-propovedi/

26 en.wikipedia.org/wiki/Islam_in_China;

Жителям Синьцзяна запретили носить «экстремистские бороды», [regnum.ru/news/ 30 марта 2017](http://regnum.ru/news/30 марта 2017)

27 Northwest China County tells students not to go to mosque during holidays, globaltimes.cn/2018/1/18

Зарим талаас ажвал эдүгээ Шинжаанд Хятадын эрх баригчдын явуулж байгаа үйл ажиллагаа нь СССР-ийн үед Дундад Азид зөвлөлтийн коммунистууд лал ба лалынхны эсрэг арга хэмжээ авч байсантай төстэй мэт. Зөвлөлт Холбоот Улсад 70 жил социализм байгуулаад лалын шашныг коммунист үзэл суртлаар солиод төрөл арилжууллаа гэсэн чинь одоо ямар болгоод тавьчихсныг харьцуулж үзвээс Хятадын эрх баригчдын дээрхи алхам хэр удаан наслах бол гэсэн сэжиг төрүүлэхээр юм.

Ес. Хилийн чанадад Хятад руугаа халдаж эхэллээ

Улаанбаатар-Бишкекийн хооронд 7 хоногтоо хэд хэдэн нислэгтэй, бид тэндхийн хяргас-киргиз ахан дүүстээ ардчиллаа түгээж буй хэмээн дотор уужраад сууж байтал гэв гэнэт «Дорнод Туркестаны тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөн» гэх бүлгийн зохион байгуулалттай уйгуруудын террорист халдлагад Бишкек дэх БНХАУ-ын Элчин сайдын яам гэнэт өртсөн тэр үйл явдал²⁸ шинэхэнээрээ байна.

Шинжааны уйгур, хасагуудын дотроос амиа золиослогч нар бий болчихжээ гэдгийг тэр өдөр, тэнд дахин нэг нотолсон доо. Тэдний нэг нь 2016 оны зун баахан тэсрэх бөмбөг тээсэн машин жолоодон Хятадын ЭСЯ-ны ханыг цөмлөн дайрч ороод өөрийгөө дэлбэчихсэн билээ. Тэр нь тажик паспорттой, уйгур иргэн байж таарсан. Сирид тулалдаж буй уйгурын террорист бүлгийн захиа даалгавраар тийнхүү амиа егүүтгэлээ гэсэн. «Фронт ан-Нусра» гэх лалын террорист байгууллагад баахан уйгур байлдаж байгаа гэх мэдээлэл тэр үеэр тархсан. Тэр дэлбэрч үхсэн нөхрийн ард энэ хэргийг бэлтгэж зохион байгуулсан 5 киргиз эрийн нэр дуулдаж байсансан. Зарим нь Туркэд явж байгаа ч гэх шиг.

Уйгур гэх түрэг хэлтэй, Хятадын Шинжаанд хүн амын олонхи нь болсон тэдгээр хүмүүс даяаршлын нөлөөнд хятадын нээлттэй байдлыг далимдуулан лалын шашиндаа гайгүй мунхарч яваа, тэр хэрээрээ Бээжингээс салан тусгаарлахыг хүсэгч сепаратистууд болчихсон, хүч хэрэглэх замаар тэр тэмцэлдээ ялна гэсэн итгэлтэй, хэдэн зуугаараа, бараг мянгаараа Сири, Иракт лалын ариун дайнд оролцож яваа, тэгснийг нь Хятадын тусгай албад тавиад туучихсан, “шашин

28 В Киргизии назвали виновника теракта у посольства КНР в Бишкеке, interfax.ru, 6 сентября 2016

шүтлэгийн эрх” гэдгийг нь өрнөдөд өөгшүүлдэг ийм л дүр зураг тэр дэлбэлэлтийн үеэр дэлхий дахинд нүдээ буутал харагдсан л даа.

Арав. Алж дуустал нь Сирид үлдээ!

Ингэхэд Сири, Иракт байлдаад хур туршлага хуримтлуулаад ирэх шинжааны мусульманчуудыг хүсэх юм биш гэдэг нь дээр тодорхой бичигдлээ. Явж явж урд хөрш маань Оросоос суралцсан нь харагдаж байх шиг. Орос ба хуучин СССР-ээс Сири, Ирак руу явж одсон исламистуудаа тэнд нь булшлаад дуустал Оросын цэргийг Сирид байлгана хэмээн Оросын албаны нөхөд ил зарласан, тэгж ч байгаа. Яг энэчлэн БНХАУ-аас тийшээ очсон, шашны солиотон болсон бүх иргэдээ тэнд л булшлуулах нь Хятадын эрх ашиг юм. Сири, Иракт радикал исламист бүлгүүдийг дуустал нь бутниргээд, гадаадын хөлсний байлдагчдаас ганцыг ч амьд үлдээхгүйгээр алж устгасан байхын тулд Хятад нь Оросын нэг адил Сири, Иракийн хууль ёсны Засгийн газруудыг дэмжсээр байна. Ганц энэ дэмжлэг биш, ялангуяа Сири нь хойшдоо шашинжаагүй төрт улс хэвээрээ үлдэж, дайны дараахи сэргээн босголтоо хийхэд нь Хятад оролцоно, тусална гэж байна. Бас нэг чухал бодлогоо Бээжингийнхэн нуусаар байна. Тэр нь Сири дэх босогчдыг дэмжиж иргэний дайныг нь дүрэлзүүлсэн өрнийнхний тэр бодлого, чиг шугам ялагдаасай гэх хятадын далд хүсэл. Асадын дэглэмийг нураах гэсэн биш исламистуудыг өөгшүүлчихсэн гэдэгтээ өрнийнхөн эцсийн дүгнэлтээ хийгээгүй, эргэж буцсаар байгаа. Сирийн Засгийн газрын цэргийн бааз руу Трампын тушаалаар америкийн тэнгисийн цэрэг агаарын цохилт өгч байхад Трамп, Си Зиньпин нар Флоридад уулзаад сууж байсан ба тэр талаар Хятадын албаны байр суурийг Орос хичнээн хүсэвч олж сонсоогүй. Тэр утгаар бол Сирийн талаархи Хятадын байр суурь Брежневийн оношлосноор “жинхэнэ зорилго нь чадамгай нуугдан байна”.

Арваннэг. Ашиг орлого

Ойрхи Дорнод, Араб ертөнц дэх эдийн засгийн ашиг сонирхлынхоо түвэгтэй, толгой эргэм бодлогод гар хөлөө хүлүүлчихсэн учраас Хятад нь жинхэнэ зорилго олж харж чадахгүй байж бас болно. Учир нь БНХАУ нь Ойрхи Дорнод, Умард Африкийн бүх улс оронтой эдийн засгийн хамтын ажиллагааны эргүүлэгт нэгэн зэрэг татагдаж

ороод байгаа. Хятадын газрын тосны хэрэглээний 60 хувийг гадаадаас авдаг гэж үзвэл 40 гаруй хувийг нь Ойрхи Дорнодоос импортолж байна.

Нефтиэр зогсохгүй Ойрхи Дорнод өөрөө Хятадын хувьд хөрөнгө оруулалтын ба аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний маш том зах зээл нь юм. Саудын Арабын газрын тосны Агамсо корпорацын 2018 оны хувьчлалаас хувьцааны 5 хувийг “China Investment Corp” гэх хөрөнгө оруулалтын фонд худалдан авна гэсэн мэдээ байна. Саудын Арабын Хаан Салманыг 2017 оны гуравдугаар сард Хятадад айлчлах үед хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрүүдэд гарын үсэг зурсан ба тэгэхэд “65 тэрбум ам.доллар” гэх тоо дагалдан тэмдэглэгдэж байсан²⁹.

Шиитийн шашны дэглэм ноёлсон Иран, Ирак хоёртой Хятад нь харилцаагаа нэгэн зэрэг идэвхтэй хөгжүүлж байна. Ираны хувьд худалдааны маш том түнш нь БНХАУ. Ираны дэд бүтэц, аж үйлдвэрийн баазын бүтээн байгуулалтад Хятадын компаниуд нэн ихээр татагдаж орсон. Ойрын 10 жилд Хятад-Ираны худалдааны эргэлтийг 600 тэрбум ам.долларт хүргэнэ гэдгийг Си Зиньпин Иранд айлчлахдаа зарлачихсан³⁰. Энэхүү 600 тэрбум гэдэг нь Хятад-Америкийн өнөөгийн худалдааны эргэлтийн үндсэн дүн. Тэгсэн атлаа Хятад нь Ираны гол дайсан Израильтай өндөр технологийн салбарт нэг гол түнш нь болчихсон явж байна.

Ирантай нөхөрсөг харилцаатай, хөрөнгө оруулалтын шүтэлцээтэй хэрнээ Ираны гол дайсан Саудын Арабтай зэвсэг нийлүүлэх хэлэлцээр байгуулсан, Израильд ихээхэн итгэл төрүүлсэн түнш нь болчихсон, тэгсэн чинь Израиль нь Сирийг үе үе бөмбөгдөөд байдаг, нэг үгэндээ Сирийн байлдагч бүх талуудыг араас нь дэмждэг, шорддог бүх улс оронтой нэгэн зэрэг найрсаг харилцаатай байх зэрэг нь Хятадын хувьд нөгөөх “жинхэнэ зорилгоо чадамгай нуудаг” бодлого нь юм болов уу.

Арванхоёр. Дүгнэлтийг орлуулж хэлэх үг

1. Зөвлөлтийн перестройка, Хятадын шинэчлэл хоёр ямар ялгаатай талаар дүгнэлтээ өгүүлэхээс аргагүй. Адил тал гэхээсээ ялгаатай тал нь давсан, түүний уршиг дагавар, үр дүнг өнөөгийн ОХУ, Төв

29 China, Saudi Arabia eye \$65 billion in deals as king visits, reuters.com/ March 16, 2017

30 China, Iran Agree to Expand Trade to \$600 Billion in a Decade, bloomberg.com/2016-01-23/

Азийн улсууд, Хятад амсаж буй тул би хэргээр оруулж бичиж байна. СССР-т ардчилал, ил тод байдалд хэт шимтгээд эдийн засгаа ор тас мартсан; харин Хятадад коммунист намын хатуу хяналт дор эдийн засгийн реформ хийж, эдийн засгаа өөрчлөн байгуулсан; үр дүн нь Зөвлөлтийн Холбоо хаост автаж, адаг сүүлд нь тарж бутарсан. Хятадад сепаратистуудын аливаа оролдлогыг таслан зогсоож устгасан. Үүнийг Төв Ази ба Шинжаан, Түвдээр харьцуулж үзэж болно.

2. Эдүгээ Хятад нь алслагдсан үндэстний хязгааруудаа эрчтэй хөгжүүлж байна. Тухайн цагтаа СССР-т ч Дундад Азиа ихээхэн хөгжүүлсэн нь Шинжааны бүтээн байгуулалтаас хол давж байсан. Гэтэл одоо энэ хоёрын байр солигджээ. Төв Азийн БНУ-уудын зарим нь гуравдагч ертөнцийн улсад харьяалагдаж, харин Дорнод Туркестан гэгдэж асан “Мусульман Хятад нь” өрнийн хөгжингүй орнуудын стандарт руу дөхөж яваа.
3. Иймд байтал хятадын эсрэг үзэл бодол Шинжаанд ил далдаар яагаад давамгайлсаар байна вэ? Шалтгаануудыг нь ч дээр үндсэндээ хэлчихлээ. Уйгуруудын терроризм Шинжааныхаа хил дотор бугших нь нэг асуудал. Хятадын бусад мужууд руу салбарлах нь өөр нэг, бүр ноцтой асуудал юм. 2014 оны гуравдугаар сард хаа холын өмнөд Юньнань мужийн төв Куньмин хотод уйгурын эр эм хэсэг террорист галт тэргээр очоод вокзал дээр хүйтэн зэвсгээр 31 хүнийг егүүтгэж, 143-ыг шархдуулсан ноцтой баримт нэгийг өгүүлэх мэт.
4. Тэсрэлтээ хүлээж битүү уугиж буй галт уултай Шинжааныг зүйрлүүлж бараг болохоор байна. Хэрэв тэнд тэсрэлт үүсвэл, тэгэх тусмаа мусульман хотонгууд үлэмж тоогоор оршин суудаг Өвөр Монгол, Хөх-хотод энэ хийрхэл үсэрхийлбэл Хятадын төр-засаг цус урсгаад нуга дарах нь мэдээж. Харин агаарын тээврээр шууд холбогдсон, Хятадтай хийх худалдаа-эдийн засаг, хөрөнгө оруулалт, хилийн худалдааны ихэнхи нь шууд хэрэгждэг Монгол-Өвөр Монголын харилцаанд ийм явдал хэрхэн нөлөөлөх талаар бидэнд бодлого хэрэгтэй мэт. Шинжаантай хил худалдаа, иргэдийн солилцоо явуулж байгаа манай баруун аймгуудаар уйгуруудын терроризм нэвтрэн орж ирэхгүй гэх баталгаа ингэхэд байна уу?

5. Адаглаад Куньминд хүйтэн зэвсгээр террорист халдлага үйлдсэн шиг гэнэтийн явдлыг Хятадын аль ч хотод Шинжааны ба бусад мужийн лалын хэт даврагчид үйлдэх бололцоотой. Тэгэхгүй гэхийн баталгаа байхгүй. Хятадын олон хотуудад сурдаг, аялдаг, наймаа хийдэг монголчууд Хятадын хотуудад мусульманчуудын хороолол, төвлөрсөн газар явахдаа ч сэрэмжтэй байхад илүүдэх юун.

**Энэхүү өгүүлэл нь зохиогч-судлаачийн судалгааны бүтээл, бүгд эх сурвалжтай, хувийн байр суурь тусгагдаагүй, тэгэх тусмаа Хятадын дотоод хэрэгт оролцох, лалын шашныг буруугаар ойлгуулах зорилгогүй, тэр утгаар Монгол Улсын Засгийн газрын ба ГХЯ-ны албан ёсны байр суурь биш болохыг анхаарна уу!*